

Төсөл

## **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АХМАДЫН САН БАЙГУУЛАН АЖИЛЛАХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8.5, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын алба(цаашид “Ажлын алба” гэнэ), Хорооны Ахмадын зөвлөлтэй байгуулсан Хамтран ажиллах Санамж бичгийн 2.1.2-д заасан “Ахмадын сан” (цаашид ”сан” гэнэ)-г байгуулах, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Санхүүгийн зохицуулах хороонд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэрт гарсан болон ажиллаж байгаа ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлш олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэхэд сангийн зорилго оршино.
- 1.3. Ажлын алба нь үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс, цалингийн нийт сангийн 3 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр санд төвлөрүүлнэ.
- 1.4. Санхүүгийн зохицуулах хороо нь өөрчлөн зохион байгуулагдсан бол сан нь уг байгууллагад харьяалагдаж байсан ахмадуудын бүртгэлийн хамт түүний эрх, үүргийг шилжүүлэн авсан этгээдэд шилжинэ.
- 1.5. Хороо нь татан буугдсан бол сангийн үйл ажиллагааг зогсоож, сангийн үлдэгдэл хөрөнгийг уг байгууллагад бүртгэлтэй ахмадуудад энэ журмын 3-т заасан зориулалтын дагуу бүрэн зарцуулж эдгээр ахмадуудад цаашид харьяалах байгууллагагүй болсон тухай мэдэгдэнэ.
- 1.6. Харьяалах байгууллага, аж ахуйн нэгж байхгүй болсон ахмад настанд дэмжлэг үзүүлэх арга хэмжээг нутгийн захиргаа, нийгмийн халамжийн үйлчилгээний болон ахмадын байгууллага хамтран зохион байгуулна.
- 1.7. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах үүргийг Ажлын алба, Ахмадын зөвлөлтэй хамтран хариуцан гүйцэтгэнэ.

### **Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт**

- 2.1. Ажлын алба нь сангийн хөрөнгийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:
  - 2.1.1. Хорооны тухайн жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс 3 /гурван хувь/ хувьтай тэнцэх хөрөнгийг санд төвлөрүүлэх;
  - 2.1.2. Сангийн тухайн жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл;
  - 2.1.3. Хороонд иргэд, байгууллагаас санд өгсөн мөнгөн хандив, мөнгөн бус хандив, тусламжийг борлуулсны орлого;
  - 2.1.4. Сангийн хөрөнгийн үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;
  - 2.1.5. бусад эх үүсвэр.

## **Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт**

- 3.1. Сангийн хөрөнгийг Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8.4-т заасны дагуу дараахь арга хэмжээнд зарцуулна:
- 3.1.1. нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж;
  - 3.1.2. түлээ, нүүрс худалдан авахад нь дэмжлэг үзүүлэх;
  - 3.1.3. хувиараа хөдөлмөр эрхлэх болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх;
  - 3.1.4. орон сууцтай болох, орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх;
  - 3.1.5. бусад зардал.
- 3.2. Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулахыг хориглоно.

## **Дөрөв. Сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, гүйцэтгэлийн тайлагнал**

- 4.1. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад мэргэжлийн хяналтын байгууллага, аудитын байгууллага, Хорооны ахмадын зөвлөл эрх хэмжээнийхээ хүрээнд тус тус хяналт тавина.
- 4.2. Сангийн хөрөнгийн орлого, зарлагын жилийн эцсийн гүйцэтгэлийн Ажлын алба болон Ахмадын зөвлөл хамтран дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор гаргаж, Хорооны удирдлага, нийт ажиллагсад болон Хорооны ахмадын байгууллагад тайлагнана.